



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 10/
32-01

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 09 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн Засаг даргын 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн ДА-2026/10/ҮА дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ-ын 2024-2025 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар дансны авлага 169,612,400.0 (нэг зуун жаран есөн сая зургаан зуун арван хоёр мянга дөрвөн зуун төгрөг), бусад авлага 132,627,200.0 (нэг зуун гучин хоёр сая зургаан зуун хорин долоон мянга хоёр зуун төгрөг), татварын авлага 16,461,000.0 (арван зургаан сая дөрвөн зуун жаран нэгэн мянган төгрөг), 12,171,000.0 (арван хоёр сая нэг зуун далан нэгэн мянга төгрөг)-ийн НӨАТ-ын өглөгийг барагдуулах боломжтой байхад өнөөг хүртэл шийдвэрлээгүй нийт **330,871,600.0** (гурван зуун гучин сая найман зуун далан нэгэн мянга зургаан зуун төгрөг)-ийн төлбөр тооцоог урьдчилан хянаж баталгаажуулаагүй бүртгэлд тайланд тусгасан зөрчил илэрлээ."

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан

4326007049

тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ.” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлага, өр төлбөрийн тооцооны үлдэгдлийг урьдчилан хянаж баталгаажуулсны дараа бүртгэл тайланд тусгаж байх
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор, Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ Барилга Захиалагч ОНӨААТҮГ-ын дарга Б.Номин ,нягтлан бодогч С.Өнөрцэцэг нарт даалгав.
3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
Т.ОДСҮРЭН



ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СЭЛЭНГЭ
БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОНӨААТҮГ-
ЫН ДАРГА
Б.НОМИН
НЯГТЛАН БОДОГЧ
С.ӨНӨРЦЭЦЭГ



